



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/482

Арвайхээр

Цэргийн ёслолын жагсаалд оролцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.6 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний их баяр наадам-Ардын хувьсгалын 98, аймаг байгуулагдсаны 88 жилийн ойн баяр наадмын хөтөлбөрийн дагуу Өвөрхангай аймгийн Арвайхээр цэргийн хүрээний төрийн цэргийн болон Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын бие бүрэлдэхүүнийг цэргийн ёслолын жагсаалд 2019 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 11.00 цагт оролцуулсугай.

2. Ёслолын жагсаалын бэлтгэлийг хангаж, сахилга зохион байгуулалтын өндөр хэмжээнд зохион байгуулан ажиллахыг Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн захирагч, Арвайхээр цэргийн хүрээний дарга, хурандаа (Б.Галбадрах)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, ажиллахыг аймгийн Баяр наадмын зохион байгуулах хорооны дарга (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100840